



# ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 291

Мандалговь

## Хөрөнгө худалдах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 3.1.д, 3.2.6.а дугаар заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Баянжаргалан сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 19’500’000 /арван есөн сая таван зуун мянга/төгрөгийн анхны өртөгтэй, 3’791’666 /гурван сая долоон зуун ерэн нэгэн мянга зургаан зуун жаран зургаа/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 90-90 дуа улсын дугаартай Hunter маркын автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 3’000’000 /гурван сая/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

3. Худалдсан эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлээс хасахыг Баянжаргалан сумын ЗДТГ-ын дарга Т.Цэвэлмаад даалгасугай.

ДАРГА  БУДЖАВ